

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

Концесс төр, хувийн хэвшлийн түншлэлийн албаны
Концессын гэрээ хийгдсэн болон хэрэгжсэн, цуцлагдсан төслийн
баримт бичиг материалыг эмхлэн цэгцлэх
ажлын хэсгийн эцсийн тайлан

Үндэсний хөгжлийн газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/10 тоот тушаалаар байгуулагдсан Концессын гэрээ хийгдсэн болон хэрэгжсэн, цуцлагдсан төслийн баримт бичиг материалыг эмхлэн цэгцлэх ажлын хэсгийн хийж гүйцгэсэн ажлын тайлан.

1. Концессын ажлын төслүүдийг 4 төрөлд хуваан ангилаж эмхлэх цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Боловсролын салбар- нийт 20 төсөлтэй Дэд ажлын хэсэг Ахлагч М.Мандах гишүүд Г.Дэлгэрмаа, З.Мэргэн.

Дэд бүтэц болон бусад төсөл- 34 төсөлтэй Дэд ажлын хэсэг Ахлагч П.Баясгалан гишүүд Ц.Энхбаяр.

Эрчим хүчний төсөл- нийт 20 төсөлтэй Дэд ажлын хэсгийн ахлагч Н.Баярчимэг гишүүд Э.Лхамгэрэл, М.Тэмүүжин.

Автозамын төсөл- нийт 12 төсөлтэй Дэд ажлын хэсгийн ахлагч Г.Содбаяр гишүүд Л.Амарбаясгалан, Б.Ундрах, Д.Отгонбаатар.

Нийт 86 төслийн баримт эмхлэн цэгцлэх ёстойгоос

Боловсролын салбарын төсөл арга хэмжээнийүүд одоо хэрэгжих шатандаа яваа төслүүд тул архивт хүлээлгэн өгөлгүй дотоод товъёог нийж эмхлэн цэгцлэн авсан. Төсөлтэй холбоотой баримтуудыг мэргэжилтэн М.Мандахын шүүгэнд хадгалдаж байна. Архивт Сургууль, цэцэрлэгийн нэг хэв маягийн 39 зураг, төсөв-34, хайрцаглан хүлээлгэн өгсөн.

Дэд бүтэц болон бусад салбарын 34 төслөөс архивт хүлээлгэн өгсөн 33 төслийг архивт дотоод товъёог хийж хүлээлгэн өгсөн 1 төсөл Хан-Уул дүүрэг дэх 300 ортой эмнэлэгийн баримт одоо төсөл хэрэгжих шатандаа яваа тул Концесс төр, хувийн хэвшлийн түншлэлийн албаны мэргэжилтэн Н.Баярчимэгт хүлээлгэн өгсөн.

Эрчим хүчний салбарын 20 төслөөс 2 төслийн материал архивт хүлээлгэн өгсөн мөн Эгийн голын Цахилгаан станцын баримтыг шууд хүлээлгэн өгсөн жич: тус баримт нь нууцын зэрэглэлтэй тул дотоод товъёог хийгдээгй жагсаалтаар хүлээлгэн өгсөн. Бусад төслийг дотоод товъёог хийж эмхлэн цэгцлэн мэргэжилтэн Н.Баярчимэгт хадгалагдаж байна.

Автозамын салбарын 12 төслөөс 5 төслийг архивт хүлээлгэн өгсөн мөн зураг төслийн баримтыг архивт шилжүүлсэн. Бусад төслийг дотоод товъёог үйлдэн Ахлах мэргэжилтэн Г.Содбаярт хадгалагдаж байна.

Архивт хийгдсэн ажлын тайлан:

Автозамын төслөөс Алтай-дарви чиглэлийн 98, 165 км автозамын 2 төсөл, Сэлэнгэ аймгийн Түнхэлийн Гүүр төсөл болон Мандалын авто замын төсөл, Дашинчилэн-Орхон чиглэлийн төсөл, Амарбаясгалант хийд чиглэлийн автозамын төсөл, Сэлэнгэ аймгийн 4 замын уулзвараас Ерөө-хүдэр чиглэлийн автозамын төсөл,

Хөвсгөл аймгийн хөвдөг гүүрний төсөл зэрэг төслүүд нийт 154 боть материалыг архивын нэгж болгосон.

Дэд бүтэц болон бусад салбарын 34 төслөөс 72 архивын нэгж хавтаслалсан.

Эрчим хүчний салбарын 20 төслөөс 64 архивын нэгж хавтаслалсан.

Нийт-290 архивын нэгж баримт хавтаслан үдсэн.

Мөн Концессын гэрээгээр хийгдсэн болон хийгдэж буй төслийн ажлын зураг 13 хайрцаг материалыг эмхлэн цэгцлэлсэн.

Жич: Концессын гэрээгээр хийгдсэн төслийн тус бүрт Чек лист хийх ажлыг Дэд ажлын хэсгийн ахлагч нар өгөх ёстой байснаас Дэд бүтэц болон бусад салбарын төслүүд Листийг хүлээлгэн өгсөн Бусад 3 салбарын Листийг хүлээлгэн өгөөгүй байна удаа дараалан хүлээлгэн өгөхийг шаардсан боловч хүлээлгэн өгөөгүй байгаа болно.